

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

2020.12.20

№	Хөтөлбөр/төслийн агуулга		Гүйцэтгэл	
1	“Авлигатай тэмцэх” үндэсний хөтөлбөр 2016-2019 он Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолын		Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.	
2	Санхүүжилтийн эх үүсвэр		Улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл, тусламжийн хөрөнгөөр	
3	Хэрэгжүүлэгч байгууллага/хэрэгжих нийт хугацаа-6 жил/		Аймаг, сумын Засаг дарга	
4	Төсөл хөтөлбөрийн зорилт <i>/суманд хамааралтай/</i>		<p>1.Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх;</p> <p>2.Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p>3.Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p>4.Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p>7.Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих;</p>	
5	Зардал	Төсөв /Нийт шаардагдах зардал	1350000	
		Үүнд	Төсөв /он/	Гүйцэтгэл

	Багц 1	1350000
6	Төсөл хөтөлбөрийн зорилт	
7	1-р зорилтын хүрээнд: Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх;	<p>Төрийн байгууллагат гарсан сул орон тооны мэдээллийн тухай бүр орон нутгийн цахим хуудас болон мэдээллийн самбаруудаар ил тод мэдээллэж, төрийн жинхэнэ албан тушаалын сул 5 орон тоо, төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын 3 сул орон тооны мэдээллийг холбогдох бичиг баримтын хамт төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлэн ажилласан. Төрийн байгууллага бүрт төрийн үйлчилгээний болон төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг танилцуулж байгууллага бүр ёс зүйн зөвлөлөө томилон үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна. 2020 оны 1 сард Ёс зүйн зөвлөлийн хүрээнд байгууллага бүртээ албан хаагчдын ёс зүйг дээшлүүлэх байгууллагын уур амьсгалыг сайжруулах зорилгоор Инээмсэглэе, Талархалын 7 хоног, Хандлагаа өөрчлөө, Эерэг бол гоё зэрэг аяныг өрнүүлэн үр дүнтэй ажилласан.</p> <p>Төрийн албан хаагчдад урамшуулал олгох болон шатлал ахиулах зэрэгт төрийн албаны тухай хуулийг дагалдан гарсан журмуудыг үндэслэн олгож байна. Энэ жил 3 албан хаагчид сахилгын шийтгэл оногдуулж тэдэнд журмын дагуу 1 жилийн хугацаанд ямар нэг урамшуулал олгохгүйгээр ажиллуулж байна.</p>
8	2-р зорилтын хүрээнд: Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх;	<p>Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангах иргэдэд төрийн үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй хүргэх зорилгоор 3-4-р сард хөдөөгийн айл өрхүүдээр ЗДТГ-ын албан хаагчдыг 3 ажлын хэсэг болгон хуваарилж малчны нийгмийн даатгал нөхөн тооцох хууль болон халамж, хөдөлмөр эрхлэлт, зээл төсөл хөтөлбөр, цаг үеийн байдлын мэдээ, мэдээллийг хүргэн ажилласан. Төрийн байгууллага бүр өөрсдийн facebook хуудсаар үйл ажиллагаагаа тогтмол мэдээллэж байна. ОНХСангийн хөрөнгөөр худалдан авах үйл ажиллагааг 100 хувь цахимаар зохион байгуулан ажилласан.</p> <p>Улсын бүртгэлийн ажилтан 7 төрлийн үйлчилгээг харьяалал харгалзахгүй үзүүлж байна. Мөн операторын үйлчилгээгээр иргэдэд</p>

		<p>54 төрлийн лавлагааг тогтмол гарган үйлчилж байна.Энэ нь иргэдэд хүнрэл учруулахгүй тэдний ажлыг хөнгөвчилсөн маш их үр дүнтэй ажил болоод байна.</p> <p>ЗДТГ-аас дотоод хяналтын баг томилогдон төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд 9-р сард хяналт шинжилгээ үнэлгээ хийж, гарсан зөрчил дутагдлыг арилгуулан, зөвлөгөө мэдээллээр ханган төрийн үйлчилгээний чанарыг сайжруулан ажилласан.</p>
9	<p>3-р зорилтын хүрээнд: Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх;</p>	<p>Сум хөгжүүлэх сан, Эрсдэлээс хамгаалах сан, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн захиран зарцуулах мэдээллийн шийдвэр нийт 18-ийг Shilendans.gov.mn сайтад Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр мэдээлэлд тухай бүр байршуулан ажиллаж байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй бараа, ажил, үйлчилгээ хүлээн авахдаа иргэн, төрийн бус байгууллагын төлөөллийг заавал оролцуулан хяналт тавин ажиллаж байна..</p>
10	<p>4-р зорилтын хүрээнд: Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх;</p>	<p>Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 1-р сард Tender.gov.mn сайтад, Шилэн дансны сайтад, Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан дүгнэлтийг тус тус байршуулсан. Бусад хяналт шалгалтын дүнг тухай бүр Шилэн дансны мэдээлэлд байршуулан ажиллаж байна. Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээллийг Tender.gov.mn сайтад мэдээллэсэн.</p>
	<p>7-р зорилтын хүрээнд: Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих;</p>	<p>Сумын Иргэний танхимд төрийн байгууллагуудын мэдээллийн самбарыг хийж байршуулсан.Үүнд байгууллага бүр жилийн ажлын төлөвлөгөө болон сар бүр хийсэн ажлын тайлангаа байршуулж иргэдэд мэдээллэж байна.Мөн иргэний танхимд 70321123 утас суурилуулан иргэдийн гомдол мэдээллийг авч, тэдэнд төрийн үйлчилгээний талаар мэдээлэл зөвлөгөөг шуурхай өгч байна.Бүх нийтийн хууль эрх зүйн боловсролыг дээшлүүлэх</p>

		хөтөлбөрийн хүрээнд 2 албан хаагч эрх зүйн хөтөчөөр бэлтгэгдсэн.Сар бүр төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ОНХСангийн төслийн хэрэгжилтэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2020 онд хийсэн ажил, үйлчилгээг сурталчилан, 2021 онд хийхээр төлөвлөж буй төслүүдийн саналыг танилцуулж, тэдний санал бодлыг тусган хэсэгчилсэн байдлаар хурал зохион байгуулсан. ЗДТГ-ын дотоод хяналтын ажлын хэсэг байгуулан төсөвт байгууллагын үйл ажиллагаа болон төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж үнэлгээ дүгнэлт өгч ажилласан.						
12	Дүгнэлт	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй ажилд иргэдийн хяналтыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулсан нь үр дүнтэй сайн ажил боллоо. Албан байгууллага бүр ёс зүйн зөвлөл байгуулан албан хаагчдыг зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж ёс зүйг сайжруулах, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтуудыг жилийн турш зохион байгуулсан нь үр дүнд хүрсэн маш сайн ажил болсон.						
13	Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ							
14	Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт /өөрийн үнэлгээ/	Биелэлт дундаж	Зорилты н тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 7
		100	хувь	100	100	100	100	100
15	Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ /ЗГХЭГ-ын үнэлгээ	Нэгдсэн үнэлгээ						

ХЯНАСАН

СУМЫН ЗАСАГ ДАРГА

Т.НЯМДАВАА